



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн
2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/07-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: Сүхбаатар сум 2022 он	Тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас:7036-3040 Цахим хаяг: Enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: Batmunkhb@audit.gov.mn Аудитор: Б.Наранцэцэг Утас: 7036-2442 Цахим хаяг: narantsetseb@audit.gov.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	5-11
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9-10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	11
3. Аудитын тайлан	13
3.1. Ерөнхий зүйл	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13-15
3.3 Сайнхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Материаллаг байдал	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	16
3.5.1 Мөнгөн хөрөнгө	16
3.5.2 Авлага	16
3.5.3 Урьдчилгаа	17
3.5.4 Бараа материал	17
3.5.5 Үндсэн хөрөнгө	18
3.5.6 Өр төлбөр	19
3.5.7 Засгийн газрын хувь оролцоо	20
3.5.8 Орлогын данс	21
3.5.9 Зардлын данс	21-23
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	23-28
3.7 Асуудлын онцлох хэсэг ба асуудлын хэсэг	28
3.8 Асуудлын гол хэсэг	29
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	30
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	31
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	32
4. Аудитын илрүүлэлт	32
4.2 Төлбөрийн акт	33-34
4.3 Албан шаардлага	35-36
4.4 Зөвлөмж	37-41
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	42-44

Товчилсон үгийн жагсаалт

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
БАУТХ	Бараа ажил үйлчилгээний төлбөр хураамж
БНАУТХ	Бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж
БҮТЭЗ	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйл
БХНС	Байгаль хамгаалах нөхөн сэргээх
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
СХС	Сум хөгжүүлэх сан
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХК	Хариуцлагатай хязгаарлагдмал компани
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭЭС	Эргэлтийн эмийн сан



МАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Б.ГАНБОЛД ТАНАА

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.03.25 № ЦА-2022/04НАСАТЗ

Танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Мандал сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мандал сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,636,144.00	7,370,527.90
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,206,686.20	3,419,026.20
33	АВЛАГА	744,579.90	1,216,487.20
34	УРЬДЧИЛГАА	2,400.00	0
35	БАРАА МАТЕРИАЛ	1,682,477.90	2,735,014.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	39,809,842.00	40,134,958.70
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	39,809,842.00	40,134,958.70
39200	Биет хөрөнгө	35,266,811.80	36,531,149.50
39300	Биет бус хөрөнгө	4,543,030.10	3,603,809.20
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	44,445,986.00	47,505,486.50
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	22,439.80	102,020.30
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	22,439.80	102,020.30
41300	Өглөг	22,439.80	102,020.30
41400	Урьдчилж орсон орлого	0	0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	44,423,546.20	47,403,466.30
51	Засгийн газрын хувь оролцоо	44,423,546.20	47,403,466.30
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	16,514,692.40	15,581,909.20
51200	Хуримтлагдсан үр дүн	18,811,064.10	22,757,873.10
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	9,097,789.70	9,063,684.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	44,445,986.00	47,505,486.50

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	26,188,104.90	27,010,256.80
11	ТАТВАРЫН ОРЛОГО	3,515,039.80	3,971,921.70
110	Орлогын албан татвар	738,232.00	900,547.70
1100	Хувь хүний орлогын албан татвар	738,232.00	900,547.70
113	Хөрөнгийн албан татвар	8,703.50	145,884.60
118	Бусад татвар, төлбөр, хураамж	2,768,104.20	2,925,489.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,183,339.50	6,224,092.20
120	Нийтлэг татварын бус орлого	4,183,339.50	6,224,092.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	18,489,725.60	16,814,242.80
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	21,970,049.40	18,542,793.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	21,970,049.40	18,542,793.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	16,605,843.50	17,721,982.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	9,945,375.60	10,103,729.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,270,722.40	1,320,881.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,228,890.40	1,240,760.90
2104	Хангамж, бараа материалын зардал	337,182.00	407,838.40
2105	Нормативт зардал	371,755.90	529,298.90
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	169,526.60	200,884.60
2107	Томилолт, зочны зардал	42,876.20	15,570.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	412,527.10	1,051,271.90
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,826,987.30	2,851,746.30
212	ТАТААС	243,864.80	223,614.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,120,341.20	597,197.40
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	4,218,055.40	8,467,462.80
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	843,255.50	5,582,483.90
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	3,374,799.90	2,884,978.90

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	23,428,994.90	22,014,581.80
11	ТАТВАРЫН ОРЛОГО	3,515,039.80	3,971,921.70
110	Орлогын албан татвар	738,232.00	900,547.70
1100	Хувь хүний орлогын албан татвар	738,232.00	900,547.70
113	Хөрөнгийн албан татвар	8,703.50	145,884.60
118	Бусад татвар, төлбөр, хураамж	2,768,104.20	2,925,489.40
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	182,456.60	283,758.10
1181	Газрын төлбөр	79,804.10	99,293.00
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	2,505,843.50	2,542,438.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,212,380.10	1,448,145.70
120	Нийтлэг татварын бус орлого	1,212,380.10	1,448,145.70
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	18,701,575.00	16,594,514.40
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	20,209,071.20	16,939,473.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	20,209,071.20	16,939,473.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	14,621,908.30	16,083,411.50
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	9,945,306.70	10,103,939.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,271,195.30	1,322,026.70
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,229,675.00	1,244,818.00
2104	Хангамж, бараа материалын зардал	202,620.40	229,656.70
2105	Нормативт зардал	365,780.50	563,168.80
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	181,563.60	210,313.90
2107	Томилолт, зочны зардал	42,876.20	15,570.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	459,581.50	1,104,215.80
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	923,309.20	1,289,701.80
212	ТАТААС	243,864.80	223,614.10
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,343,298.00	632,447.40
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	3,219,923.70	5,075,108.80
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	1,258,488.70	3,389,768.80
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,258,488.70	3,389,768.80
2200	Дотоод эх үүсвэрээр	1,258,488.70	3,389,768.80
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-1,258,488.70	-3,389,768.80
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-8,000.00	-473,000.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	8,000.00	473,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	1,953,435.00	1,212,340.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	253,251.20	2,206,686.20
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,206,686.20	3,419,026.20

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	41,008,552.20	0	41,008,552.20
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	40,194.00	0	40,194.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	41,048,746.30	0	41,048,746.30
9	Тайлант үеийн үр дүн	3,374,799.90	0	3,374,799.90
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	44,423,546.20	0	44,423,546.20
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	44,423,546.20	0	44,423,546.20
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	46,044.00	0	46,044.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	44,469,590.20	0	44,469,590.20
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-32,557.90	0	-32,557.90
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	81,455.00	0	81,455.00
19	Тайлант үеийн үр дүн	2,884,978.90	0	2,884,978.90
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	47,403,466.30	0	47,403,466.30

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	19,652,482.40	18,392,903.11	276,203.83
21	УРСГАЛ ЗАРДАЛ	16,358,230.30	15,651,943.67	276,253.53
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	15,793,315.80	15,114,859.09	276,253.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10,161,931.00	9,974,730.16	0.00
210101	Үндсэн цалин	6,861,782.60	6,623,850.43	762.99
210102	Нэмэгдэл	2,573,841.70	2,774,913.58	891.82
210103	Унаа хоолны хөнгөлөлт	43,648.00	28,636.59	0.00
210104	Урамшуулал	528,087.50	520,584.11	-1,654.82
210105	Гэрээт ажлын хөлс	154,571.20	26,745.44	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,368,276.50	1,305,665.33	0.00
210201	Тэтгэврийн даатгал	957,168.60	918,438.59	0.00
210202	Тэтгэмжийн даатгал	102,777.10	101,884.34	0.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	82,221.90	79,501.08	0.00
210204	Ажилгүйдлийн даатгал	20,555.00	18,643.33	0.00
210205	Эрүүл мэндийн даатгал	205,553.90	187,197.98	0.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,469,072.20	1,244,368.55	0.00
210301	Гэрэл, цахилгаан	208,678.70	118,499.72	6,694.96
210302	Түлш, халаалт	1,121,357.70	1,066,115.84	-6,694.96
210303	Цэвэр, бохир ус	139,035.80	59,752.99	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	211,815.50	209,232.37	415.70
210401	Бичиг хэрэг	33,250.30	34,191.78	0.00
210402	Тээвэр, шатахуун	81,470.50	81,212.23	0.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	38,634.90	30,193.29	0.00
210404	Ном, хэвлэл	11,909.10	10,010.40	415.70
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	14,861,400.00	14,700.30	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	31,689,300.00	38,924.36	0.00
2105	Нормативт зардал	394,320.80	309,693.97	0.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	53,684.90	53,492.68	0.00
210502	Хоол, хүнс	300,380.30	216,974.19	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	40,255.60	39,227.10	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	431,396.50	419,897.98	-560.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	171,704.90	160,821.20	349.80
210602	Тавилга	32,849.80	32,849.80	-1,349.80
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,688.30	1,687.95	0.00
210604	Урсгал засвар	225,153.50	224,539.03	440.00
2107	Томилолт, зочны зардал	45,549.40	15,390.49	0.00
210702	Дотоод албан томилолт	20,549.40	6,021.29	0.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	25,000.00	9,369.20	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,058,232.90	1,025,206.68	4,735.00

Мандал сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,038,818.50	1,011,423.64	4,735.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	17,158.50	13,032.30	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	709.00	28.74	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	615.90	243.60	0.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	200.20	128.40	0.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	730.80	350.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	652,721.00	610,673.55	271,662.83
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	610,741.50	568,826.15	271,152.83
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	41,979.50	41,847.40	510.00
212	ТАТААС	223,614.10	223,614.10	0.00
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	223,614.10	223,614.10	0.00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	223,614.10	223,614.10	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	341,300.40	313,470.48	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	341,300.40	313,470.48	0.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	185,933.10	162,630.44	0.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	120,666.80	120,666.80	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	34,700.50	30,173.24	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,751,952.10	2,267,959.44	-49.70
220001	Барилга байгууламж	880,815.30	628,607.22	-304.57
221001	Их засвар	240,425.00	76,356.01	0.00
223001	Бусад хөрөнгө	1,630,711.80	1,562,996.21	254.87
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	542,300.00	473,000.00	0.00
230001	Эргэж төлөгдөх зээл	542,300.00	473,000.00	0.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	19,652,482.40	18,315,804.08	15,601.11
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	11,279,067.30	11,041,488.72	-5,847.49
310001	Улсын төсвөөс санхүүжих	0.00	0.00	-5,856.64
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	11,279,067.30	11,041,488.72	9,151.09
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	7,564,373.50	6,903,042.35	5,863.09
320001	Орон нутгийн төсвөөс	6,587,437.60	5,926,106.45	5,863.09
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	976,935.90	976,935.90	0.00
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	71,540.60	41,971.84	0.00
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	71,540.60	41,971.84	0.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	737,501.00	329,301.18	0.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	250,000.00	329,013.18	-4,892.40
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,500.00	288.00	4,892.40
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	482,001.00	0.00	0.00

Мандал сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	522,338.23
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	444,083.61

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,485,477.095
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,639,827.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,255,441.36
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	135,729.22
210101	Үндсэн цалин	78,552.27
210102	Нэмэгдэл	53,855.45
210104	Урамшуулал	3,321.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,176.35
210201	Тэтгэврийн даатгал	13,327.38
210202	Тэтгэмжийн даатгал	1,302.20
210203	ҮОМШӨ-ний даатгал	994.35
210204	Ажилгүйдлийн даатгал	354.60
210205	Эрүүл мэндийн даатгал	1,197.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	899.01
210301	Гэрэл, цахилгаан	899.01
2104	Хангамж, бараа материалын зардал	26,311.79
210401	Бичиг хэрэг	5,499.19
210402	Тээвэр, шатахуун	7,015.93
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,144.87
210404	Ном, хэвлэл	7,930.90
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,156.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,564.90
2105	Нормативт зардал	253,474.78
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	197,661.98
210502	Хоол, хүнс	24,573.55
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	31,239.25
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	37,106.60
210601	Багаж, техник, хэрэгсэл	24,046.90
210602	Тавилга	2,250.00
210604	Урсгал засвар	10,809.70
2107	Томилолт, зочны зардал	180.00
210702	Дотоод албан томилолт	180.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	94,819.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	94,819.80
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	689,743.81
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	689,644.81
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	99.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	384,385.93
2132	Бусад урсгал шилжүүлэг	75,556.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	75,556.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	308,829.93

**Мандал сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн
гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	5,842.35
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	302,987.58
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	845,649.80
2200	Дотоод эх үүсвэрээр	845,649.80
220001	Барилга байгууламж	807,310.07
223001	Бусад хөрөнгө	32,249.73
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,090.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,485,481.91
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,485,481.91
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	21,079.87
131103	ЗГНХ, ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,333.94
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,476,179.80
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	322,726.80
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	659,161.50
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	4.82
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4.82

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын төсвийн төвлөрүүлэн захирагч /Цаашид Мандал сумын ТТЗ гэх/-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт болон төлбөрийн цахим баримттай холбоотойгоор өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Наранцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мандал сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 1/129 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Мандал сумын ТТЗ-ийн 2021 оны үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Хүнээ дээдлэн, үйлдвэрлэлтийг дэмжиж, Хамтын хүчээр сумаа хөгжүүлбэ” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах, байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх,

- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,

- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын, түүнчлэн бүс нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэм-соёлын зориулалттай барилга байгууламж барьж байгуулахад орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалт хийх ажлыг дэмжиж, зохион байгуулах,
- Төрийн ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн ИТХ-д оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийнхээ татварын орлогыг хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Төрийн болон тухайн орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар” шинэчлэгдсэн,
- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- УИХ-аас 2021 оны 6 дугаар сард Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан даатгуулагчийн сард төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийн доод хэмжээ нь Засгийн газраас баталсан тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тэтгэврийн даатгалд 11.5 хувиас, тэтгэмжийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалд тус бүр 1.0 хувиас багагүй байна гэж өөрчлөлт оруулсан,
- Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 2021 оны 43 дугаар тогтоолоор төсөвт зардлыг хэмнэх, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах шаардлагыг төсвийн бүх шатны байгууллагын төсөв захирагч нарт даалгасан,
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах “Босго үнэ шинэчлэн батлах тухай” журмыг баталсан,
- Малын тоо толгойн албан татварын тухай хууль 2021 оны 01 дүгээр сарын 01-нээс мөрдөгдөж эхэлсэн,
- Аймгийн ТЭЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан,

- Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам” шинэчлэн батлагдсан,
- Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам” шинэчлэн батлагдсан,
- Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлд заасан Төрийн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах хэсэгт 2021 оны 7 дугаар сард нэмэлт өөрчлөлт оруулсан,
- Засгийн газрын 2020 оны 184 дүгээр тогтоолоор “Ойгоос бэлтгэж ашиглах 1 шоо-метр хэрэглээний мод, түлээнд ногдуулах төлбөрийн хэмжээг шинэчлэн баталсан” гэх мэт.
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн гэх мэт

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд ТТЗ-ийн дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж дүгнэж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд Мандал сумын Санхүүгийн албанаас 5 чиглэлээр дотоод хяналт хэрэгжүүлэхээр төлөвлөгөөг боловсруулан батлуулж, 6 байгууллагад түүвэрчилсэн хяналтыг хэрэгжүүлж нийт 12 зөвлөмж өгч ажилласан байна.

Мандал сумын ТТЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд 2021 онд аймгийн ТЕЗ-ийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас дотоод хяналт шалгалт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мандал сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн

үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох **18,542,793.90** мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 278,141.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу **194,699.3** мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн болно.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 2,206,686.2 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 3,419,026.2 мянган төгрөг болж, 1,212,340.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1 Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	2,206,686.2	3,419,026.2	1,212,340.0
Дүн	2,206,686.2	3,419,026.2	1,212,340.0

Эх сурвалж: Мандал сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд тайлагнагдсан 2,859,487.6 мянган төгрөг ОНХО-ын дансанд, 298,738.9 мянган төгрөг ОНХС-ийн дансанд, 115,450.1 мянган төгрөг БХНС барьцаа хөрөнгийн дансанд, 135,915.2 мянган төгрөг СХС-ийн дансанд, 9,434.4 мянган төгрөг Хэрх, Түнхэл тосгоны ЭМТ-ийн дансанд тус тус байршиж байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 744,580.0 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 1,216,487.2 мянган төгрөг болж, 471,907.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	1,865.0	135.0	(1,730.0)
Татаас, санхүүжилтийн авлага	8,582.3	242,259.3	233,677.0
Зээлийн хүүгийн авлага	30,133.2	28,895.2	(1,238.0)
Зээлийн авлага	703,999.5	945,197.7	241,198.2
Дүн	744,580.0	1,216,487.2	471,907.2

Эх сурвалж: Мандал сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын үлдэгдэлд насжилт өндөртэй СХС-ийн үндсэн зээлийн 533,306.3 мянган төгрөг болон зээлийн хүүгийн 28,313.98 мянган төгрөг, ЭМДСангаас авах татаас санхүүжилтийн Хэрх тосгоны ЭМТ-ийн 234,482.3 мянган төгрөгийн, Түнхэл тосгоны ЭМТ-ийн 4,422.6 мянган төгрөгийн авлага тус тус бүртгэлтэй.

Аудитын илрүүлэлт:

- Хэрхийн ЭМТ нь төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас 135.0 мянган төгрөгийн НДШ-ийн авлага үүсгэсэн байна.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа данс нь тайлант оны эцэст үлдэгдэлгүй тайлагнагдсан байна.

Хүснэгт №3 Урьдчилгаа дансны үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	2,400.0	-	(2,400.0)
Дүн	2,400.0	-	(2,400.0)

Эх сурвалж: Мандал сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Сумын ИТХ-ын "Гамшгийн эрсдэлийн үнэлгээний тойм судалгаа"-ны ажлын урьдчилж төлсөн 2,400.0 мянган төгрөгийн төсөл арга хэмжээ тайлант онд хэрэгжиж үлдэгдэлгүй тайлагнагдсан байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын 1,682,477.9 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 2,735,014.5 мянган төгрөг болж, 1,052,536.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалттай материал	187,817.4	173,412.5	(14,404.9)
Эм боох материал	27,599.6	104,952.2	77,352.6
Бичиг хэргийн материал	21,622.1	14,295.9	(7,326.2)
Аж ахуйн материал	312,115.1	327,623.3	15,508.2
Сэлбэг хэрэгсэл	3,717.5	1,845.0	(1,872.5)
Түлш, шатах тослох материал	10,112.2	9,704.4	(407.8)
Барилгын засварын материал	45,792.0	37,890.9	(7,901.1)
Хүнсний материал	11,762.5	12,984.5	1,222.0
Бусад хангамжийн материал	1,061,939.5	2,052,305.8	990,366.3
Дүн	1,682,477.9	2,735,014.5	1,052,536.4

Эх сурвалж: Мандал сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын данс нь тайлант онд 4,896,137.9 мянган төгрөгийн материал худалдан авч, дээд шатны байгууллагаас 5,710.8 төгрөгийн материал шилжүүлэн авсан, хандиваар 174,147.9 мянган төгрөгийг хүлээн авсан зэргээр нэмэгдсэн байна.

Харин 2,069,300.9 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, ОНХС-ийн эх үүсвэрээр бэлтгэсэн 763,693.3 мянган төгрөгийн, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 1,518,511.7 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээг бараа материалын дансаар дамжуулан ашиглагч байгууллагад тус тус шилжүүлсэн, бүтцийн өөрчлөлтөөр Хот тохижуулах газар нь ААТҮГ болсонтой холбоотойгоор 8,391.4 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлэн, 25,304.59 мянган төгрөгийн бараа материалыг акталсан зэргээс хасагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

- 1 дүгээр сургууль нь бараа материалын тодруулга тайланд зардлын эдийн засгийн ангиллыг 6,453.4 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн,
- 6-р цэцэрлэг нь нормын хувцас, зөөлөн эдлэл зардлаас худалдан авсан 800.0 мянган төгрөгийн хөдөлмөр хамгааллын хувцсыг бараа материалын бусад хангамжийн материал дансанд орлого авч тайлагнасан.
- 1 дүгээр сургууль нь бараа материалын тодруулга тайланд 6,453.4 мянган төгрөгийн зардлын эдийн засгийн ангиллыг зөрүүтэй бүртгэсэн.
- Тайлант онд дараах байгууллагууд нь нийт **643,007.6** мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна. баталгаажуулаагүй. Үүнд:
 - ✓ ЗДТГ нь 255,717.8 мянган төгрөг,
 - ✓ ИТХ нь 69,968.4 мянган төгрөг,
 - ✓ Хүүхдийн ордон нь 22,389.2 мянган төгрөг,
 - ✓ Тарнийн сургууль, цэцэрлэг нь 22,962.8 мянган төгрөг,
 - ✓ Үйлст эмнэхүй ӨЭМТ нь 10,963.6 мянган төгрөг,
 - ✓ Хараа манал ӨЭМТ нь 6,719.3 мянган төгрөг,
 - ✓ Ачит амирлуулагч ӨЭМТ нь 4,096.6 мянган төгрөг,
 - ✓ Хэрх тосгоны соёлын төв нь 4,998.7 мянган төгрөг,
 - ✓ Түнхэл тосгоны Захирагчийн алба нь 3,320.0 мянган төгрөг,
 - ✓ Түнхэл тосгоны соёлын төв нь 2,927.9 мянган төгрөг,
 - ✓ Ойн анги нь 2,520.3 мянган төгрөг,
 - ✓ Хэрх тосгоны Захирагчийн алба нь 388.6 мянган төгрөг,
 - ✓ Номын сан нь 272.7 мянган төгрөг,
 - ✓ Хэрх тосгоны сургууль нь 5,305.6 мянган төгрөг,
 - ✓ Түнхэл тосгоны сургууль нь 3,217.9 мянган төгрөг,
 - ✓ 1 дүгээр сургууль нь 278.1 мянган төгрөг,
 - ✓ 1 дүгээр цэцэрлэг нь 24,797.0 мянган төгрөг,
 - ✓ 2 дугаар сургууль нь 51,066.6 мянган төгрөг,
 - ✓ 2 дугаар цэцэрлэг нь 19,478.3 мянган төгрөг,
 - ✓ 3 дугаар сургууль нь 15,691.1 мянган төгрөг,
 - ✓ 4 дүгээр цэцэрлэг нь 40,356.0 мянган төгрөг,
 - ✓ 5 дугаар цэцэрлэг нь 67,679.1 мянган төгрөг,
 - ✓ 6 дугаар цэцэрлэг нь 7,892.0 мянган төгрөгийн гэх мэт.

3.5.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн /анхны өртгөөр/ 47,280,505.3 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 46,128,709.5 мянган төгрөг болж, 1,151,795.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	26,280,699.5	28,357,899.7	2,077,200.2
Авто-тээврийн хэрэгсэл	1,200,797.4	959,836.8	(240,960.6)

Мандал сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Машин тоног төхөөрөмж(компьютер)	3,012,886.1	2,720,887.1	(291,999.0)
Тавилга, аж ахуйн эд хогшил	1,501,140.6	1,287,339.4	(213,801.2)
Зам, гүүрийн байгууламж	2,913,671.5	3,761,518.3	847,846.8
Дуусаагүй барилга, байгууламж	3,993,696.4	3,482,383.5	(511,312.9)
Ном	363,186.8	365,097.3	1,910.5
Бусад үндсэн хөрөнгө	3,461,717.7	1,578,748.5	(1,882,969.2)
Программ хангамж	28,829.2	27,412.1	(1,417.1)
Бусад биет бус хөрөнгө	4,523,880.1	3,587,586.9	(936,293.2)
Дүн	47,280,505.4	46,128,709.6	(1,151,795.8)

Эх сурвалж: Мандал сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 1,151,795.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 748,719.2 мянган төгрөг, балансаас балансад шилжүүлэн авсан 1,968,821.9 мянган төгрөг, үнэ төлбөргүй хандиваар авсан 1,096,119.3 мянган төгрөг, аймгийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн хатуу хучилттай замын 1,497,145.75 мянган төгрөгийг бусад эх үүсвэрээр авсан зэрэг нийт 5,310,806.2 мянган төгрөгөөр нэмэгдэж, балансаас балансад шилжүүлсэн 1,262,149.5 мянган төгрөг, шинээр байгуулагдсан “Тохилог хараа” ААТҮГ-т шилжүүлсэн 3,268,792.0 мянган төгрөг, 772,404.7 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хассан зэргээр хорогдсоноос тус тус шалтгаалсан байна.

Дуусаагүй барилга дансанд 3,482,383.5 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна. Үүнд:

- Тарнийн 8 дугаар багийн барилгын 40,000.0 мянган төгрөгийн, /цэвдэгтэй газар баригдаад улсын комисс ашиглалтад хүлээж аваагүйгээс /
- Авто замын 1,070,983.5 мянган төгрөгийн, /
- ЗДТГ-ын дотоод засварын ажлын 194,992.4 мянган төгрөгийн,
- Түнхэл тосгоны төрийн албан хаагчийн байр болон соёл спортын цогцолборын барилгын 1,078,366.4 мянган төгрөгийн,
- Хэрх тосгоны соёлын төвийн барилгын 154,072.5 мянган төгрөгийн,
- Хэрх тосгоны цэцэрлэгийн барилгын 188,731.9 мянган төгрөгийн,
- Хэрх тосгоны ЭМТ-ийн барилгын 435,500.0 мянган төгрөгийн,
- Мандал сумын 3 дугаар багийн хүүхдийн тоглоомын талбайн 319,736.8 мянган төгрөгийн дуусаагүй барилга тус тус бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- Үйлст эмнэхүй, Хараа манал, Ачит амирлуулагч ӨЭМТөвүүд нь жилийн эцсийн тайлан гарахаас өмнө эд хөрөнгийн үлдэгдлийг тоолж баталгаажуулаагүй байна.
- Түнхэл тосгоны сургууль нь санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлогын дүнг бараа материал болон үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн орлогын дүнгээс зөрүүтэй илэрхийлсэн.

3.5.6 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 22,439.8 мянган төгрөг байсан бол

эцсийн үлдэгдэл 102,020.3 мянган төгрөг болж, 79,580.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Байгууллагад төлөх өглөг	22,439.8	81,059.7	58,619.9
Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	20,960.6	20,960.6
Дүн	22,439.8	102,020.3	79,580.5

Эх сурвалж: Мандал сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 8,320.1 мянган төгрөгийн БХНС арга хэмжээний барьцаа, 63,526.3 мянган төгрөгийн ОНХО, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ажлын барьцаа, ЭМДЕГ-аас авах санхүүжилтийн дутуугаас Хэрх тосгоны ЭМТ-ийн 27,787.1 мянган төгрөг, Түнхэл тосгоны 2,386.8 мянган төгрөгийн зэрэг нийт 102,020.3 мянган төгрөгийн өр төлбөр тайлагнагдсан байна.

Аудитын илрүүлэлт:

- Түнхэл тосгоны ЭМТ-ийн эмийн сангийн төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас **2,386.8** мянган төгрөгийн эмийн өр төлбөр үүсгэсэн.
- 3 дугаар сургууль нь өмнөх оны санхүүгийн тайланд өр төлбөр үүсгэлгүйгээр НДШ-ийн шимтгэлийн өглөг гэж тайлант оны батлагдсан төсвөөс 200.9 мянган төгрөгийг төлсөн.
- Түнхэл тосгоны сургууль нь өмнөх оны санхүүгийн тайланд өр төлбөр үүсгэлгүйгээр НДШ-ийн шимтгэлийн зөрүүгийн өглөг гэж тайлант оны батлагдсан төсвөөс 2,114.9 мянган төгрөгийг төлсөн.
- Хэрх тосгоны сургууль нь өмнөх оны санхүүгийн тайланд өр төлбөр үүсгэлгүйгээр НДШ-ийн зөрүү гэх үндэслэлээр тайлант оны батлагдсан төсвөөс 2,219.0 мянган төгрөгийг шилжүүлсэн.

3.5.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 44,423,546.2 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 47,403,466.2 мянган төгрөг болж, 2,979,920.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7 Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	16,514,692.4	15,581,909.2	(932,783.2)
Хуримтлагдсан үр дүн	18,811,064.1	22,757,873.1	3,946,809.0
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	9,097,789.7	9,063,683.9	(34,105.8)
Дүн	44,423,546.2	47,403,466.2	2,979,920.0

Эх сурвалж: Мандал сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5.8 Орлогын данс

Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд Ойн анги 40,000.0 мянган төгрөг, Түнхэл тосгоны Захирагчийн алба 4,500.0 мянган төгрөг, ЗДТГ 1,000.0 мянган төгрөгийн зэрэг нийт 45,500.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр Ойн ангийн талбай тусгаарлалтын орлогын 58,165.5 мянган төгрөг, Түнхэл тосгоны Захирагчийн албаны түрээсийн төлбөрийн 4,892,4 мянган төгрөг, СХС-ийн эргэн төлөлтийн 264,799.7 мянган төгрөг зэрэг нийт **327,857.6** мянган төгрөг болон туслах үйл ажиллагааны хүрээнд бий болсон СХС-ийн дансанд худгийн эргэн төлөлтийн **288.0** мянган төгрөгийн орлогыг тус тус төвлөрүүлсэн бол Ковид-19 цар тахлаас шалтгаалан ЗДТГ-ын цайны газар ажиллаагүйн улмаас ЗДТГ-ын өөрийн орлогын төлөвлөгөө биелээгүй байна.

3.5.9 Зардлын данс

Зардлын данстай холбоотой 56,418.5 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

ИТХ:

- Нарийн бичгийн дарга С.Ичинхорлоод **200.0** мянган төгрөгийн албан томилолтыг давхардуулан олгосон.
- Мэдээлэл сурталчилгааны батлагдсан төсвөөс хуралдааны зардалд 2,157.7 мянган төгрөг, багийн ИНХ-ын цалингийн зардлаас ИТХ-ын цалингийн зардалд 672.6 мянган төгрөг гэх мэт хөтөлбөр хооронд нийт **2,830.0** мянган төгрөгийг гүйлгэн, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.
- Өмч хамгаалах зөвлөлийн хурлаар засвар үйлчилгээ зайлшгүй хийх шаардлагатай эсэх, төсөв тооцоо, судалгаа зэрэг асуудлыг хэлэлцүүлж, дүгнүүлэлгүйгээр автомашины засвар үйлчилгээнд нийт **20,541.3** мянган төгрөгийн сэлбэг хэрэгслийн зардал гаргасан.
- Холбогдох албан тушаалтны захирамж, шийдвэр гараагүй буюу зарцуулах эрх үүсээгүй байхад **2,016.9** мянган төгрөгийг зарцуулж, бүртгэл тайланд тусгасан.

ЗДТГ:

- Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон Д.Байгалмаад **1,913.0** мянган төгрөгийн тэтгэмж илүү олгосон.
- Ахмад санхүүчдийг хүлээн авахад 2,972.3 мянган төгрөг, Түшиг сумын албан хаагчдыг хүлээн авахад 1,003.0 мянган төгрөг зэрэг нийт **3,975.3** мянган төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зориулалт бусаар зарцуулсан.
- Холбогдох албан тушаалтны захирамж, шийдвэр гараагүй буюу зарцуулах эрх үүсээгүй байхад ЗДНХ-өөс **11,135.1** мянган төгрөгийг зарцуулж, бүртгэл тайланд тусгасан.

Түнхэл тосгоны ЭМТ:

- Ур чадварын нэмэгдлийг зөрүүтэй тооцоолж К.Төмөрчөдөрт **233.7** мянган төгрөг, албан тушаал хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг уг хавсран гүйцэтгэж буй албан тушаалын цалингаас бус эрхэлж буй албан тушаалын үндсэн цалингаас тооцож, А.Орникт **102.0** мянган төгрөгийг илүү олгосон,
- Хугацаа дууссан **241.6** мянган төгрөгийн эмийг *Төндөрийн эмийн* эргэлтийн эмийн сангаас нөхөн авч эргэлтийн эмийн сангаас холбогдох албан тушаалтны тушаал, шийдвэргүйгээр зарлагадсан.
- Эмийн сангийн тайлан тооцоог тухай бүр хянаж, баталгаажуулаагүйгээс **1,341.5** мянган төгрөгийн эмийн орлогыг дутуу төвлөрүүлсэн.

Түнхэл тосгоны Захирагчийн алба:

- Нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардлаас албан хаагчдад биеийн тамирын хувцас худалдан авахад **1,108.6** мянган төгрөгийг зарцуулсан.

Хэрх тосгоны ЭМТ:

- Тайлант оны батлагдсан орон тоонд тусгагдаагүй дотоод аудиторын албан тушаалыг эм зүйчээр хавсран гүйцэтгүүлж, **567.4** мянган төгрөгийн цалин олгосон.
- Эмийн сангийн **2,580.5** мянган төгрөгийн кассын орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд орлого орсон тухай бүр бус бөөн дүнгээр төвлөрүүлсэн.

Тарнийн сургууль:

- **339.5** мянган төгрөгийн шатахууныг шаардах хуудсаар зарлагадаагүй, жолоочийн тооцооны хуудсанд ирсэн, явсан болон зарцуулсан км, спидометрийн заалтыг бүрэн бүртгээгүй, автомашины 100 км-т зарцуулах шатахууны нормыг мөрдөж ажиллаагүй.

Тарнийн цэцэрлэг:

- **426.0** мянган төгрөгийн шатахууныг шаардах хуудсаар зарлагадаагүй, жолоочийн тооцооны хуудсанд ирсэн, явсан болон зарцуулсан км, спидометрийн заалтыг бүрэн бүртгээгүй, автомашины 100 км-т зарцуулах шатахууны нормыг мөрдөж ажиллаагүй.

ӨЭМТ:

- Үйлст эмнэхүй, Хараа манал, Ачит амирлуулагч ӨЭМТ нь төлбөрийн хүсэлтийг Хаан банкны тамга тэмдэг, гарын үсгээр баталгаажуулаагүй.

Бусад: Төсвийн төлөвлөлтийг бодит судалгаа, мэдээлэл дээр үндэслэн зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар нь үнэн зөв төлөвлөөгүйгээс нийт **6,866.1** мянган төгрөгийг зардлын бүлэг хооронд гүйлгэн заруулсан байна. Үүнд:

- ✓ ИТХ нь нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлаас 750.0 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн БНАҮТХ-д, 519.8 мянган төгрөгийг БАҮТХураамжид зэрэг нийт **1,269.8** мянган төгрөгийг

- ✓ ЗДТГ нь бусдаар гүйцэтгүүлсэн БНАУТХ-аас 275.0 мянган төгрөгийг мэдээлэл технологийн зардалд, 397.0 мянган төгрөгийг хог хаягдлын зардалд зэрэг нийт **672.0** мянган төгрөгийг,
- ✓ Түнхэл тосгоны Захирагчийн алба нь бусдаар гүйцэтгүүлсэн БНАУТХ-аас 141.0 мянган төгрөгийг БҮТЭЗ худалдан авах зардалд, 260.7 мянган төгрөгийг шуудан холбооны зардалд зэрэг нийт **401.7** мянган төгрөгийг,
- ✓ Хэрх тосгоны Захирагчийн алба нь бусдаар гүйцэтгүүлсэн БНАУТХ-аас 396.9 мянган төгрөгийг автомашины татварын зардалд, 108.9 мянган төгрөгийг даатгалын зардалд, 300.0 мянган төгрөгийг мэдээлэл технологийн зардалд, цалингийн зардлаас 487.1 мянган төгрөгийг НДШ-ийн зардалд зэрэг нийт **1,292.9** мянган төгрөгийг,
- ✓ Номын сан нь хөдөлмөр хамгааллын хэрэгслийн зардлаас 80.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн БНАУТХ-аас 123.0 мянган төгрөгийг тус тус БҮТЭЗ худалдан авахад нийт **203.0** мянган төгрөгийг,
- ✓ Ойн анги нь БҮТЭЗ-ийн зардлаас 87.0 мянган төгрөгийг урсгал засварын зардалд, цалингийн зардлаас 235.7 мянган төгрөгийг НДШ-ийн зардалд, бусдаар гүйцэтгүүлсэн БНАУТХ-аас 369.1 мянган төгрөгийг автомашины даатгал, 114.1 мянган төгрөгийг тээврийн хэрэгслийн татварын зардалд зэрэг нийт **805.9** мянган төгрөгийг,
- ✓ Хүүхдийн ордон нь нормын хувцас, зөөлөн эдлэл худалдан авах зардлаас 176.4 мянган төгрөгийг БҮТЭЗ худалдан авахад, шуудан холбооны зардлаас 99.0 мянган төгрөгийг мэдээлэл технологийн зардалд, 108.8 мянган төгрөгийг тээвэр шатахууны зардалд, шуудан холбооны зардлаас 58.0 мянган төгрөгийг тээвэр шатахууны зардалд зэрэг нийт **442.2** мянган төгрөгийг,
- ✓ Түнхэл тосгоны Соёлын төв нь нормын хувцас, зөөлөн эдлэл худалдан авах зардлаас 36.8 мянган төгрөгийг БҮТЭЗ худалдан авах зардалд, бараа үйлчилгээний зардлаас 87.3 мянган төгрөгийг БҮТЭЗ худалдан авах зардалд зэрэг нийт **124.1** мянган төгрөгийг,
- ✓ Хэрх тосгоны Соёлын төв нь нормын хувцас зөөлөн эдлэл худалдан авах зардлаас 36.8 мянган төгрөгийг БҮТЭЗ, хөдөлмөр хамгааллын хэрэглэл худалдан авах зардлаас 79.2 мянган төгрөгийг ном худалдан авахад зэрэг нийт **116.0** мянган төгрөгийг,
- ✓ Тарнийн сургууль нь хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас **250.0** мянган төгрөгийг албан томилолтын зардалд,
- ✓ Тарнийн цэцэрлэг нь хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас **296.0** мянган төгрөгийг албан томилолтын зардалд,
- ✓ 1 дүгээр цэцэрлэг нь бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжаас **992.5** мянган төгрөгийг бараа материалын зардалд тус тус бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь

тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн татварын болон татварын бус орлого бүрдүүлэлт:

Сумын ИТХ-ын “Мандал сумын 2021 оны тодотгосон төсөв батлах тухай” 2021 оны 24 дүгээр тогтоолоор тайлант онд 2,225,719.0 мянган төгрөгийн татварын орлого, 685,500.0 мянган төгрөгийн татварын бус орлого, нийт **2,911,219.0** мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 5,048,329.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 173.4 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №8 Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үйл ажиллагааны орлого	150,000.0	273,239.3	123,239.3	182.1
Хөрөнгийн орлого	318,400.0	397,727.6	79,327.6	124.9
Хөрөнгө борлуулсны орлого	100,000.0	229,580.7	129,580.7	229.6
Бууны албан татвар	13,200.0	12,818.0	(382.0)	97.1
Улсын тэмдэгийн хураамж	63,000.0	94,506.9	31,506.92	150.0
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	40,000.0	43,525.4	3,525.4	108.8
Газрын төлбөр	56,159.0	36,941.3	(19,217.7)	65.8
Дуудлага худалдаа	30,000.0	62,351.7	32,351.7	2дах
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	2,326.0	2,142.2	(183.8)	92.1
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	5,000.0	16,360.2	11,360.2	3.3дах
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	143,061.0	145,725.8	2,664.8	101.8
Ойн нөөц ашигласны төлбөр	1,304,573.0	2,523,935.9	1,219,362.9	193.5
Малын тоо толгойн албан татвар	0	133,066.5	133,066.5	100.0
Хүү, торгуулийн орлого	340,000.0	431,791.6	91,791.6	126.9
Бусад орлого	300,000.0	581,558.5	281,558.5	193.8
Төсөвт байгууллагын өөрийн орлого	45,500.0	63,057.9	17,557.9	138.6
Нийт дүн	2,911,219.0	5,048,329.7	2,137,110.7	173.4

Эх сурвалж: Мандал сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн орлогын төлөвлөгөө давж биелэхэд ойн нөөц ашигласны төлбөр 1,219,362.9 мянган төгрөг, малын тоо толгойн албан татвар 133,066.5 мянган төгрөг, бусад орлого 281,558.5 мянган төгрөг, хөрөнгө борлуулсны орлого 129,580.7 мянган төгрөг, үйл ажиллагааны орлого 123,239.3 мянган төгрөгөөр давж биелсэн нь голлон нөлөөлсөн байна.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

Давж биелсэн орлого:

- Ойн нөөц ашигласны төлбөр 1,219,362.9 мянган төгрөгөөр буюу 1.9 дахин давж биелсэн нь ойгоос мод бэлтгэх гэрээг нэмж байгуулсан, тухайн жилийн ойн нөөц ашигласны төлбөрийн хэмжээ нэмэгдэж шинэчлэгдсэн болон хуш модны самрын орлого өссөнтэй холбоотой байна.

- Малын тоо толгойн албан татварын орлого төлөвлөгдөөгүй бөгөөд Малын тоо толгойн албан татварын тухай хууль 2021 оноос хэрэгжиж эхэлснээр 133,065.5 мянган төгрөгийн орлого төвлөрсөн байна.

- Ус, рашааны нөөц ашигласны төлбөр 11,360.2 мянган төгрөгөөр давж биелсэн нь “Бороо гоулд” ХХК-ийн өмнөх оны төлөгдөөгүй үлдэгдлийг төвлөрүүлснээс шалтгаалсан байна.

- Хөрөнгө борлуулсны орлого 129,580.7 мянган төгрөгөөр давж биелсэн нь хадгаламжийн хүүгийн болон үл хөдлөх хөрөнгийн борлуулалт өссөнөөс шалтгаалсан байна.

Тасарсан орлого:

- Газрын төлбөрийн орлого 19,217.7 мянган төгрөгөөр тасарсан нь “Бороо гоулд” ХХК-иас тооцож авах авлага тайлант онд төлөгдөөгүйтэй холбоотой байна.
- Бууны албан татварын орлого тасарсан нь иргэдийн эзэмшлийн галт зэвсэг шаардлага хангахгүйн улмаас Цагдаагийн газарт хураагдаж ашиглалтаас хасагдсанаас шалтгаалсан байна.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төсөлд төсвийн орлогыг 1,400,736.5 мянган төгрөг, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 4,028,176.5 мянган төгрөг, орон нутгийн байгууллагуудын зардлын санхүүжилтийг 5,428,913.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийг сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 10 дугаар тогтоолоор төсвийн орлогыг 2,146,966.1 мянган төгрөг, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 2,126,166.1 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 899,668.4 мянган төгрөг, ОНХС-ын урьд оны үлдэгдлээс 145,201.0 мянган төгрөг, ТЗШ-ийн байгууллагын санхүүжилтийг 11,155,710.2 мянган төгрөг, сумын төсөвт аймгийн ОНХС-аас олгох хот тохижуулалтын 77,267.4 мянган төгрөг, ЭМДС-ийн санхүүжилтийг 71,540.6 мянган төгрөг, СХС-ийн зээлийн эргэн төлөлт 546,800.0 мянган төгрөг зэрэг нийт **18,973,003.5** төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 16 дугаар тогтоолоор аймгийн төсвийг тодотгосонтой холбоотойгоор сумын ИТХ-ын 2021 оны 24 дүгээр тогтоолоор дараах өөрчлөлтийг оруулан төсвийн орлого, зарлагыг нэмэгдүүлж **19,620,091.9** мянган төгрөгөөр баталсан байна. Үүнд:

- ✓ ТЗШ-ийн байгууллагын санхүүжилтийг 90,966.8 мянган төгрөг, татварын болон татварын бус орлогыг 764,252.9 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн бол аймгаас олгох санхүүгийн дэмжлэгийг 71,412.7 мянган төгрөг, сумын урьд оны үлдэгдлээс 136,718.5 мянган төгрөгийн санхүүжилтийг тус тус бууруулан тодотгосон,

✓ Ковид-19 цар тахал болон малын шүлхий өвчөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан ЗДНХ-ийн зардлыг 100,000.0 мянган төгрөг, ЗДТГ-ын урсгал зардлыг 127,019.9 мянган төгрөг, ИТХ-ын урсгал зардлыг 10,000.0 мянган төгрөг, Түнхэл тосгоны соёлын төвийн урсгал зардлыг 11,971.5 мянган төгрөг, Түнхэл тосгоны Захирагчийн албаны урсгал зардлыг 10,000.0 мянган төгрөг, Хэрх тосгоны Захирагчийн албаны урсгал зардлыг 6,232.5 мянган төгрөг, Хэрх тосгоны Соёлын төвийн урсгал зардлыг 5,000.0 мянган төгрөг, ЭМТ-ийн тогтмол зардлыг 10,000.0 мянган төгрөг, сумын ОНХО-ыг 312,488.4 мянган төгрөг, ЕБС-ийн тогтмол зардлыг 51,843.5 мянган төгрөг, цэцэрлэгийн тогтмол зардлыг 725.6 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, Спортын ордны санхүүжилт аймагт шилжсэнтэй холбоотойгоор урсгал санхүүжилтийг 89,159.7 мянган төгрөгөөр бууруулсан байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/372 дугаар захирамжаар ТЗШ-ийн байгууллагуудын төсөвт зохицуулалт хийгдэж тус сумын ТЗШ-ийн байгууллагуудаас нийт 32,390.5 мянган төгрөгийг нэмж 11,279,067.3 мянган төгрөг болгосноос шалтгаалж батлагдсан төсөв **19,652,482.4** мянган төгрөг болж өөрчлөгдсөн байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 14 хөтөлбөрт зориулан **19,652,482.4** мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 16,358,230.3 мянган төгрөгийг урсгал зардалд, 2,751,952.1 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, СХС-ийн зээлд 542,300.0 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Нийт зардлын 2,054,753.4 мянган төгрөгийг аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс, 2,911,219.0 мянган төгрөгийг орон нутгийн орлогоос, 1,666,965.2 мянган төгрөгийг оны эхний үлдэгдлээс, 11,279,067.3 мянган төгрөгийг ТЗШ-ээс, 71,540.6 мянган төгрөгийг ЭМД-ын сангаас, 546,800.0 мянган төгрөгийг СХС-ийн эх үүсвэрээс, 976,935.9 мянган төгрөгийг ОНХС-аас, 145,201.0 мянган төгрөгийг ОНХС-ын урьд оны үлдэгдлээс тус тус санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 11,279,067.3 мянган төгрөгийг ТЗШ-ээс, 41,971.8 мянган төгрөгийг ЭМД-ын сангаас, 2,054,753.4 мянган төгрөгийг аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс, 3,871,353.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 976,935.9 мянган төгрөгийг ОНХС-аас, 64,213.5 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 265,087.7 мянган төгрөгийг СХС-аас зэрэг нийт 18,553,382.7 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **18,392,903.1** мянган төгрөг буюу 93.6 хувьтай тайлагнагдсан нь ЭМД-ын сангийн санхүүжилтийг гүйцэтгэлээр нь олгосон, ТЗШ-ийн санхүүжилтийн хэмнэгдсэн зардлыг татан төвлөрүүлсэн болон орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилтийг гүйцэтгэлээр олгосон зэргээс шалтгаалсан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, НДШ-ийн зардал нийт 249,812.0 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 224,703.6 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 2,583.1 мянган төгрөгөөр, нормативт зардал 84,626.8 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 11,498.5 мянган төгрөгөөр, томилолтын зардал 30,158.9 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 33,026.2 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 42,195.4 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

Тайлант онд сумын төсвийн хөрөнгө оруулалт, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх нийт 31 төсөл, арга хэмжээнд 2,797,620.5 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 2,267,959.4 мянган төгрөгийн санхүүжилт олгож, ... мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

3.6.3 Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 21,079.9 мянган төгрөг, ЗДНХ-өөс 6,333.9 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 1,476,179.8 мянган төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 322,726.8 мянган төгрөг зэрэг нийт 2,485,481.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна. Үүнд:

✓ Хандиваар ЗДТГ-т ААНБайгууллагаас 10,320.4 мянган төгрөг, Түнхэл тосгоны сургуульд төгсөгчдөөс 10,759.5 мянган төгрөг зэрэг нийт 21,079.9 мянган төгрөгийг хандивын орлого бүртгэгдсэн,

✓ Дээд шатны төсвийн захирагчаас буюу сумын ИТХ-д аймгийн ИТХ-аас хамтарсан багийн зардалд 3,000.0 мянган төгрөг, Ойн ангид БОАЖГ-аас биотехникийн арга хэмжээний зардалд 1,500.0 мянган төгрөг, ЗДТГ-т Статистикийн хэлтсээс малын ашиг шимийн гарцын судалгааны зардалд 3,997.2 мянган төгрөг, мал тооллогын зардалд 1,643.6 мянган төгрөг, аймгийн ЗДТГ-аас шагналын 1,000.0 мянган төгрөг, бичил уурхай эрхлэгчдийн урамшууллын 1,500.0 мянган төгрөг, малчдын зөвлөгөөний уулзалтын шатахууны зардалд 159.1 мянган төгрөг, Хэрхийн ЗА-нд 168.1 мянган төгрөг, аймгийн ЗДТГ-аас Хөгжимт чуулгад 4,820.0 мянган төгрөг, аймгийн ОНХС-ийн болон замын сангийн төсөл арга хэмжээний санхүүжилтийн 1,316,238.9 мянган төгрөг, ЭМДЕГ-аас ӨЭМТ-үүдэд 212,061.3 мянган төгрөг, Хэрх тосгоны ЭМТ-д 383,184.7, Түнхэл тосгоны ЭМТ-д 63,915.5 мянган төгрөг, аймгийн ЭМГ-аас ковидын илүү цагийн нэмэгдэл хөлс болон нэг удаагийн тэтгэмжийн зардалд Хэрх тосгоны ЭМТ-д 27,996.6 мянган төгрөг, Түнхэл тосгоны ЭМТ-д 31,998.4 мянган төгрөг, ӨЭМТ-үүдэд 33,078.4 мянган төгрөг, ЕБС, цэцэрлэгүүдэд БСУГ-аас төслийн санхүүжилт 53,549.5 мянган төгрөг, ариутгалын зардалд 1,040.0 мянган төгрөг, ӨЭМТ-өөс ЕБ-ын 3 дугаар сургуульд ковидын илүү цагийн 636.6 мянган төгрөгийг тус тус шилжүүлсэн,

✓ Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор Сйн ангид улсын тэмдэгтийн хураамжийн 127,049.9 мянган төгрөг, ЗДТГ-т тендерийн орлогын 1,463.0 мянган төгрөг, газрын дуудлага худалдааны дэнчингийн 32,786.9 мянган төгрөг, техник хяналтын зардлын 2,284.9 мянган төгрөг, чанарын баталгааны 5 хувийн барьцаа хөрөнгийн 77,111.3 мянган төгрөг, Түнхэл тосгоны ЭМТ-ийн эмийн орлогын 29,290.0 мянган төгрөг, Хэрх тосгоны ЭМТ-ийн эргэлтийн эмийн сангийн орлогын 2,580.5 мянган төгрөг, ЕБ-ын 4-р сургууль, Хэрх тосгоны цэцэрлэг болон Соёлын төвд ковидын илүү цагийн нэмэгдэл хөлсний 7,707.0 мянган төгрөг, Хэрх тосгоны Соёлын төвийн түрээсийн орлогын 3,443.2 мянган төгрөг, Спортын ордны талбай түрээсийн 615.0 мянган төгрөг, Хөгжимт чуулгын өөрийн орлогын 1,771.7 мянган төгрөг, Түнхэл тосгоны Соёлын төвийн түрээсийн орлогын 400.0 мянган төгрөг, ЕБС-уудын номын түрээсийн орлогын 28,941.9 мянган төгрөг, 1 дүгээр сургуулийн сургалтын төлбөрийн 2,914.0 мянган төгрөг, татаас санхүүжилтийн 4,014.1 мянган төгрөг, 2 дугаар сургуулийн 168.0 мянган төгрөг, 4 дүгээр сургуулийн заалны түрээсийн 160.0 мянган төгрөг, Нархан цэцэрлэгийн тендерийн орлогын 35.0 мянган төгрөг зэрэг нийт 322,726.8 мянган төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардалд 3,321.5 мянган төгрөг, НДШ-д 180.1 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардалд 3,675.1 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 755.9 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжид 11,025.7 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 436,939.6 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 839,559.8 мянган төгрөг зэрэг нийт 1,448,505.5 мянган төгрөгийг зарцуулж, 5,842.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

3.7 Асуудлын онцлох хэсэг ба бусад асуудлын хэсэг

3.7.1 ТТЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн дахин үнэлгээний нэмэгдэл дансанд бүртгэлтэй хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү нь үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайланд бүрэн тусгагдаагүй буюу аль хөрөнгөд хамаарах нь тодорхой бус байгаа тул үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд хөрөнгө тус бүрд хамаарах дахин үнэлгээний нэмэгдлийг тусган оруулж, НББОУС 16 “Үндсэн хөрөнгө” стандартыг баримтлан ажиллах.

3.7.2 ТТЗ-ийн харьяа байгууллагуудын татварын цахим системийн гатварын үлдэгдлийн тооцоололд цалин хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан татвар болон суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татвар нь санхүүгийн тайлангаас зөрүүтэй тайлагнагдсан байгаа нь татварын авлага, ер төлбөр үүсэх эрсдэлийг үүсгэж байна. Иймд 2022 оны эхний хагас жилд багтаан тооцоо нийлж, татварын үлдэгдлийг тулган баталгаажуулах шаардлагатай байна.

3.7.3 Санхүүгийн тайланд СХС-гаас олгосон зээлийн авлага 945,197.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсанаас 2011-2018 онд олгосон хугацаа хэтэрсэн үндсэн зээлийн 533,306.3 мянган төгрөг, хүү, алдангийн авлагын 28,313.9 мянган төгрөг буюу нийт 561,620.8 мянган төгрөгийн зээлийн авлагыг барагдуулахаар

холбогдох шатны шүүхэд хандаж, шийдвэрлүүлэх дорвитой арга хэмжээ аваагүй байгаа нь найдваргүй авлага үүсэх, СХС-ийн эргэлтийг удаашруулах, эх үүсвэр дутагдах эрсдэлийг үүсгэж байна. Иймд цаашид хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулах талаар бодитой арга хэмжээг зохион байгуулах шаардлагатай.

3.7.4 Тайлант онд төлбөрийн баримтын цахим системд илүү шивэгдсэн ЗДТГ-ын 28,458.6 мянган төгрөг, ИТХ-ын 911.2 мянган төгрөг, Хэрх тосгоны Захирагчийн албаны 939.4 мянган төгрөг, Ойн ангийн 7,000.0 мянган төгрөг, Номын сангийн 1,585.2 мянган төгрөг, Хүүхдийн ордны 1,981.8 мянган төгрөг, Хэрх тосгоны ЭМТ-ийн 5,546.6 мянган төгрөг, Түнхэл тосгоны ЭМТ-ийн 661.5 мянган төгрөг, Түнхэл тосгоны Соёлын төвийн 505.0 мянган төгрөг, Хэрх тосгоны Соёлын төвийн 871.1 мянган төгрөг, Тарнийн сургууль, цэцэрлэгийн 732.1 мянган төгрөгийн зэрэг нийт 49,192.5 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалт байгаа нь анхан шатны баримтгүй болон баримтын бүрдэлгүй орлого, зарлагын гүйлгээг хүлээн зөвшөөрч данс бүртгэлд тусгах эрсдэлийг үүсгэж байна. Иймд төлбөрийн баримтын цахим системийг үнэн зөв хөтлөх, алдаатай эсвэл буруу шивэгдсэн баримтуудыг тухай бүр залруулж байх шаардлагатай байна.

3.8 Асуудлын гол асуудал

3.8.1 Ойн анги нь орон нутгийн төсөвт төвлөрүүлбэл зохих 127,094.9 мянган төгрөгийн улсын тэмдэгтийн хураамжийг байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан төвлөрүүлж, орон нутгийн дансанд жилд 3 удаа төвлэрүүлсэн байна.

3.8.2 ЗДТГ нь ковидтой холбоотойгоор нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан ААНБайгууллага болон иргэдээс нийт 10,320.4 мянган төгрөгийн хандив хүлээн авч, зарцуулсан байна. ЗДТГ нь Зочин төлөөлөгч хүлээн авах зардлын ангилалд батлагдсан төсвөөс тус суманд ажилласан улсын магадлангийн комиссын байр, хоолны зардалд *иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээ, хугацаа тогтоосон байдалд хяналт шалгалт хийсэн*/ 1,710.9 мянган төгрөг, ХАА-н менежментийн багийн байр, хоолны зардалд 4,956.4 мянган төгрөг гэх мэт тус суманд ажилласан байгууллагуудын зардлыг санхүүжүүлсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ын “код 210703: Зочин төлөөлөгч хүлээн авах: МУ-д гадаад улс орнуудаас албан ажлын айлчлалаар ирэх зочин, төлөөлөгч, ... айлчлахтай холбоотойгоор гарах зочид буудал, хоол унаа, бэлэг дурсгалын эд зүйлс бэлтгэх зардал” гэсэн заалтыг зөрчиж байна. Иймд зочин төлөөлөгч хүлээн авах зардлын зүйлд батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах шаардлагатай байна.

3.8.3 Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан сумын Засаг даргын бүрэн эрхийн хүрээнд Ковид 19 өвчний үед төрийн тусгай албадын бэлэн байдлыг хангасан гэх үндэслэлээр ОНХО-ын санхүүжилтээр Мандал сум дахь Цагдаагийн газарт 150,000.0 мянган төгрөгийн, Онцгой байдлын хэлтэст 9,990.0 мянган төгрөгийн, Шүүх шинжилгээний албанд 10,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий суудлын автомашин, Мандал сум дахь сум дундын Прокурорын газарт 10,000.0 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж

худалдан авч өгсөн байна. Цаашид сумын төсвийн хөрөнгөөр улсын төсөвт байгууллагуудыг санхүүжүүлэхгүй байх нь зүйтэй юм.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хүснэгт №9 Шилэн данс

Д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Мэдээлээгүй
1	Засаг дарга	155	118	37	-
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	149	145	3	1
3	Засаг даргын Тамгын газар	149	139	10	-
4	Хүүхдийн ордон	149	148	1	-
5	Ойн анги	149	142	6	1
6	Номын сан	149	99	50	-
7	Түнхэл тосгоны Захирагчийн алба	149	115	34	-
8	Хэрх тосгоны Захирагчийн алба	149	140	9	-
9	Түнхэл тосгоны Соёлын төв	149	115	33	1
10	Хэрх тосгоны Соёлын төв	149	147	1	1
11	Тарнийн сургууль	149	137	12	-
12	Түнхэл тосгоны ЭМТ	149	131	17	1
13	Хэрх тосгоны ЭМТ	149	114	31	4
14	Үйлст эмнэхүй ӨЭМТ	4	1	3	-
15	Ачит амирлуулагч ӨЭМТ	4	1	3	-
16	Хараа манал ӨЭМТ	4	3	1	-
	Нийт дүн	1,955	1,695	251	9

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Мандал сумын ТТЗ-ийн тайлант оны үйл ажиллагаанд 19,652,482.4 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 18,392,903.1 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 6.4 хувиар хэмнэсэн.

Хүснэгт №10 Харьяа төсвийн байгууллагуудын төсвийн хэмнэлтийг тодруулбал:

Д/д	Байгууллагын нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэмнэлт /хувиар/
1	Хүүхдийн ордон	187,728.4	186,316.4	0.8

Мандал сумын ТТЗ-ийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2	Түнхэл тосгоны Соёлын төв	115,257.7	113,978.9	1.1
3	Хэрх тосгоны Захирагчийн алба	201,402.0	198,580.9	1.4
4	Түнхэл тосгоны Захирагчийн алба	210,811.6	206,357.0	2.1
5	Хэрх тосгоны Соёлын төв	112,093.7	108,772.0	2.9
6	Номын сан	138,176.3	133,476.6	3.4
7	Тарнийн сургууль	183,850.5	175,446.3	4.6

Эдгээр нь ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....батлагдсан төсөөт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасантай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4 дэх “Энэ тогтоол батлагдахаас өмнө ... худалдан авах ажиллагаа зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, ... худалдан авалтыг зохион байгуулахгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн дараах ажил гүйлгээнүүд гарсан байна. Үүнд:

1. Түнхэл тосгоны Захирагчийн алба нь нормын хувцас, зөөлөн эдлэлийн батлагдсан төсвөөс албан хаагчдад **1,108.6** мянган төгрөгийн биеийн тамирын хувцас худалдан авсан,
2. ОНХО-ын эх үүсвэрээр Мандал сум дахь Прокурорын газарт **4,100.0** мянган төгрөгийн тавилга худалдан авсан.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 12,677.4 мянган төгрөгийн 5 төлбөрийн акт, 43,554.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 10 албан шаардлага, 76,852.3 мянган төгрөгийн 6 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт№11 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	5	12,667.4	4	4,918.6	1	7,748.8	80.0
Албан шаардлага	10	43,554.3	8	39,631.2	2	3,923.1	80.0
Зөвлөмж	6	76,852.3	4	15,728.5	2	61,123.8	66.7
Нийт	21	133,074.0	16	60,278.3	5	72,795.7	76.2

Өмнөх аудитаар өгсөн холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх, зайлшгүй шаардлага үүсээгүй байхад төсвийн тодотгол хийхгүй байх зэрэг зөвлөмжийг тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг

үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Өмнөх аудитаар тогтоосон Түнхэл тосгоны захирагч, 5 дугаар багийн Засаг дарга Ч.Оюунгэрэлд өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийг илүү тооцож, олгосон 7,748.8 мянган төгрөгийг нөхөн төлүүлэх төлбөрийн актыг барагдуулаагүй тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй.....нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалтын дагуу Түнхэл тосгоны Захирагчид хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

3.11.1 Санхүүгийн тайлангийн аудитын цаг хугацааны хязгаарлагдмал байдлын улмаас ОНХС, ОНХО-ын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, худалдан авах ажиллагаа, бүртгэл тайлагнал, гүйцэтгэлтэй холбоотой асуудлуудыг шалган баталгаажуулах боломжгүй байсан учир сэдэвчилсэн гүйцэтгэлийн аудитуудаар гүнзгийрүүлэн шалгах нь зүйтэй юм.

3.11.2 Хэрх тосгоны ЭМТ нь эргэлтийн эмийн сангийн орлого, зарлагын данс бүртгэлийг тусад нь хөтөлдөггүй, нэмэгдүүлсэн үнийн тайлан зэргийг гаргаж баталгаажуулаагүй зэргээс эмийн сангийн орлого, зарлагыг цаг хугацааны хязгаарлагдмал байдлын улмаас тулган баталгаажуулах боломжгүй байсан учир дараагийн аудитаар гүнзгийрүүлэн шалгах нь зүйтэй юм.

4. Аудитын илрүүлэлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 28 төсвийн байгууллага, орон нутгийн төсөл, сангийн 2, нийт 30 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 12 байгууллагын санхүүгийн тайланд бие даасан дүгнэлт гаргаж, 16 байгууллага, 2 төсөл сангийн тайлан түүвэрт хамрагдсан байна.

Мандал сумын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 1,074,164.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 120,950.2 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 5,466.2 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон, 169,750.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 777,997.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 31 зөвлөмжийг хүргүүллээ.

Аудитад хамрагдсан харьяа 12 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна.

ТТЗ-ийн түвшний аудитаар нийт 639,809.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 18,969.1 мянган төгрөгийн алдааг залруулж, 5,466.2 мянган төгрөгийн зөрчилд 6 төлбөрийн акт тогтоож, 165,215.4 мянган төгрөгийн зөрчилд 9 албан шаардлага хүргүүлэн, 450,158.8 мянган төгрөгийн алдаа зөрчилд 8 зөвлөмжийг хүргүүлэв.

4.1 Залруулсан алдаа:

Аудитын явцад дараах алдааг залруулав. Үүнд:

- Үндсэн хөрөнгөд Ойн анги нь 249.9 мянган төгрөг, Хүүхдийн ордон нь 546.9 мянган төгрөг, Хэрх тосгоны Захирагчийн алба нь 1,567.9 мянган төгрөг, Хэрхийн ЭМТ 11,098.3 мянган төгрөг, Түнхэл тосгоны ЭМТ нь 1,083.5 мянган төгрөгийн зэрэг нийт 14,546.5 мянган төгрөгийн элэгдэл байгуулалгүй, санхүүгийн үр дүнг дутуу илэрхийлсэн,
- Түнхэл тосгоны ЭМТ нь ЭМДСангаас авах хөнгөлөлттэй эмийн болон ковидын дархлаажуулалтын зэрэг нийт 4,422.6 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгалгүй орхигдуулсан,

4.2 Төлбөрийн акт:

Иргэдийн төлөөлөгчдийн хурал:

1. Аймгийн ИТХ-аас “Төрийн албан хаагчдын чадавхыг бэхжүүлэх” чиглэлийн хүрээнд 4 өдрийн сургалтыг зохион байгуулж, албан томилолтын зардлыг тооцож олгосон атал ИТХ-ын нарийн бичгийн дарга С.Ичинхорлоод 200.0 мянган төгрөгийг сумын ИТХ-ын төсвөөс давхардуулан олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон албан томилолтын зардлыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

Засаг даргын Тамгын газар:

2. Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон албан хаагчид олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийг тухайн албан тушаалын үндсэн цалингийн 3 жилийн дунджаар бус сүүлийн 2 жилийн үндсэн цалингаар тооцож Д.Байгалмаад 1,913.0 мянган төгрөг илүү олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ын 2.1 дэх “Нэг удаагийн буцалтгүй тусламж тооцох үндсэн цалингийн хэмжээг тогтоохдоо тухайн албан тушаалын үндсэн цалингийн сүүлийн 3 жилийн дунджаар тооцно” гэсэн заалтыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон нэг удаагийн буцалтгүй тусламжийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

Түнхэл тосгоны Захирагчийн алба:

3. Нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардлаас албан хаагчдад биеийн тамирын хувцас худалдан авахад **1,108.6** мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь *“Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”*, Засгийн газрын 2021 оны 43 тогтоолын 1.4 дэх *“Энэ тогтоол батлагдахаас өмнө ... худалдан авах ажиллагаа зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, ... худалдан авалтыг зохион байгуулахгүй байх”*, Сангийн сайдын *“Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай”* 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтад *“нормын хувцас зөөлөн эдлэл 210503”*-ын тодорхойлолтыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн *“Нийцсэн бөгөөд зохистой байх”* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

Түнхэл тосгоны ЭМТ:

4. Ур чадварын нэмэгдлийг тогтоосон хэмжээнээс зөрүүтэй тооцож, К.Төмөрчөдөрт **233.7** мянган төгрөг, албан тушаал хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг хавсран гүйцэтгэж буй албан тушаалын цалингаас бус эрхэлж буй албан тушаалын үндсэн цалингаас тооцож А.Орникд **102.0** мянган төгрөгийг тус тус илүү олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дахь *“Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь *“дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”* гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн *“Нийцсэн бөгөөд зохистой байх”* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон нэмэгдлийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

5. Эмийн сангийн тайлан тооцоог тухай бүр хянаж, баталгаажуулаагүйгээс **1,341.5** мянган төгрөгийн эмийн орлогыг дутуу төвлөрүүлсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь *“дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”*, Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2 дахь *“Төсвийн байгууллага нь ... өөрийн үйл ажиллагааны орлогыг Төрийн сангийн нэгдсэн дансанд саадгүй байршуулна”* гэсэн заалтыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн *“Нийцсэн бөгөөд зохистой байх”* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дутуу төвлөрүүлсэн орлогыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

Хэрх тосгоны ЭМТ:

6. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс орон тоонд тусгагдаагүй дотоод аудиторын албан тушаалыг эм зүйч Н.Отгонжаргалаар хавсран гүйцэтгүүлж, хавсран ажилласны нэмэгдэлд **567.4** мянган төгрөг олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3-д *“Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”* гэж заасныг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн *“Нийцсэн бөгөөд зохистой байх”* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон нэмэгдлийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

4.3 Албан шаардлага:

Төсвийн төвлөрүүлэн захирагч:

1. Зайлшгүй шаардлага үүсээгүй байхад буюу төсвийн төлөвлөгөөнөөс давсан орлогоос ОНХО-ын зардлыг **35,683.2** мянган төгрөгөөр, ЗДТГ, ИТХ, Түнхэл болон Хэрх тосгоны Захирагчийн алба, Соёлын төвүүдийн багаж, техник хэрэгсэл, тавилга худалдан авах болон урсгал засварын зардлыг **119,963.2** мянган төгрөгөөр зэрэг нийт **155,646.4** мянган төгрөгөөр нэмэгдүүлж, төсвийн тодотгол хийсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 34 дугаар зүйлийн 34.2 дахь *“Засаг дарга дараах тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголыг болгосруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ”, 34.2.2: “Урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж, орон нутгийн төсөв алдагдалтай болох нөхцөл байдал бий болсон”* гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн *“Нийцсэн бөгөөд зохистой байх”* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зайлшгүй шаардлага үүсээгүй байхад төсөвт тодотгол хийхгүй байх албан шаардлага хүргүүлэх.

Иргэдийн төлөөлөгчдийн хурал:

2. ИТХ-ын мэдээлэл сурталчилгааны батлагдсан төсвөөс хуралдааны зардалд 2,157.7 мянган төгрөг, багийн ИНХ-ын цалингийн зардлаас ИТХ-ын цалингийн зардалд 672.6 мянган төгрөг гэх мэт хөтөлбөр хооронд нийт **2,830.3** мянган төгрөгийг гүйлгэн, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь *“Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”,* Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх *“Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”,* Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан *“Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын 3.1.6 дахь “... дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг албан бичгээр авсан байх”* гэсэн заалтуудыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн *“Нийцсэн бөгөөд зохистой байх”* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлэх.

Засаг даргын Тамгын газар:

3. Засаг даргын нөөц хөрөнгөөс ахмад санхүүчдийг хүлээн авахад 2,972.3 мянган төгрөг, Түшиг сумын албан хаагчдыг хүлээн авахад 1,003.0 мянган төгрөг зэрэг нийт **3,975.3** мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан 2 дугаар зүйлийн 2.1 дэх заалтыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “*Нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ЗДНХ-ийн батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх албан шаардлага хүргүүлэх.

Хэрх тосгоны ЭМТ:

4. Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас НДШ-ийн **135.0** мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, ер төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “*Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэсэн заалтыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулж, гүйцэтгэж байх албан шаардлага хүргүүлэх.

Түнхэл тосгоны ЭМТ:

5. Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас **2,386.8** мянган төгрөгийн эмийн сангийн эмийн өр төлбөр үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “*Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “*Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдах, төлбөр тооцоог урьдчилан хянах замаар өр төлбөр үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэх.

6. Түнхэл тосгоны ЭМТ нь хугацаа дууссан **241.6** мянган төгрөгийн эмийг *Итендерийн эмийн* эргэлтийн эмийн сангаас нөхөн авч, холбогдох албан тушаалтны тушаал, шийдвэргүйгээр зарлагдсан *эмийн сангаас* нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно*” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтад үндэслэн ажил гүйлгээг гүйцэтгэж байх албан шаардлага хүргүүлэх.

Өрхийн ЭМТ:

7. Үйлст эмнэхүй, Хараа манал, Ачит амирлуулагч ӨЭМТөвүүд нь жилийн эцсийн тайлан гарахаас өмнө эд хөрөнгийн үлдэгдлийг тоолж баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1: "Жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайлан гаргахын өмнө хөрөнгийн тооллого хийж байх албан шаардлага хүргүүлэх.

Сахилгын хариуцлага тооцуулах:

8. Өмнөх аудитаар өгсөн /Түнхэл тосгоны захирагч буюу төрийн улс төрийн албан хаагч Ч.Оюунгэрэлд өндөр насны тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж 7,748.8 мянган төгрөг илүү олгосон/ төлбөрийн актыг барагдуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, ... бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно." гэсэн заалтыг үндэслэн Түнхэл тосгоны захирагч, 5 дугаар багийн Засаг даргын үүрэг гүйцэтгэгч Х.Хүрэл-Эрдэнэд сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэх.

9. Хэрх тосгоны ЭМТ нь аудитад шаардлагатай баримт материалыг ирүүлэлгүйгээр аудитын үйл ажиллагаанд саад учруулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, ...аудитын үйл ажиллагаанд саад учруулсан ... бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно." гэсэн заалтыг үндэслэн Хэрх тосгоны ЭМТ-ийн эмийн санч Н.Отгонжаргалд сахилгын хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэх.

4.4 Зөвлөмж

4.4.1 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой:

Илрүүлэлт: Төсвийн төлөвлөлтийг бодит судалгаа, мэдээлэл дээр үндэслэн зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар нь үнэн зөв төлөвлөөгүйгээс нийт 5,873.6 мянган төгрөгийг зардлын бүлэг хооронд гүйлгэн заруулсан байна. Үүнд:

- ✓ ИТХ нь нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлаас 750.0 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардалд, 519.8 мянган төгрөгийг БАҮТХураамжид зэрэг нийт **1,269.8** мянган төгрөгийг,
- ✓ ЗДТГ нь бусдаар гүйцэтгүүлсэн БНАҮТХ-аас 275.0 мянган төгрөгийг мэдээлэл технологийн зардалд, 397.0 мянган төгрөгийг хог хаягдлын зардалд зэрэг нийт **672.0** мянган төгрөгийг,
- ✓ Түнхэл тосгоны Захирагчийн алба нь бусдаар гүйцэтгүүлсэн БНАҮ зардлаас 141.0 мянган төгрөгийг БҮТЭЗ худалдан авах зардалд, 260.7 мянган төгрөгийг шуудан холбооны зардалд зэрэг нийт **401.7** мянган төгрөгийг,
- ✓ Хэрх тосгоны Захирагчийн алба нь бусдаар гүйцэтгүүлсэн БНАҮТХ-аас 396.9 мянган төгрөгийг автомашины татварын зардалд, 108.9 мянган төгрөгийг даатгалын зардалд, 300.0 мянган төгрөгийг мэдээлэл технологийн зардалд, цалингийн зардлаас 487.1 мянган төгрөгийг НДШ-ийн зардалд зэрэг нийт **1,292.9** мянган төгрөгийг,
- ✓ Номын сан нь хөдөлмөр хамгааллын хэрэгслийн зардлаас 80.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн БНАҮТХ-аас 123.0 мянган төгрөгийг тус тус БҮТЭЗ худалдан авахад нийт **203.0** мянган төгрөгийг,
- ✓ Ойн анги нь БҮТЭЗ-ийн зардлаас 87.0 мянган төгрөгийг урсгал засварын зардалд, цалингийн зардлаас 235.7 мянган төгрөгийг НДШ-ийн зардалд, бусдаар гүйцэтгүүлсэн БНАҮТХ-аас 369.1 мянган төгрөгийг автомашины даатгал, 114.1 мянган төгрөгийг тээврийн хэрэгслийн татварын зардалд зэрэг нийт **805.9** мянган төгрөгийг,
- ✓ Хүүхдийн ордон нь нормын хувцас, зөөлөн эдлэл худалдан авах зардлаас 176.4 мянган төгрөгийг БҮТЭЗ худалдан авахад, шуудан холбооны зардлаас 99.0 мянган төгрөгийг мэдээлэл технологийн зардалд, 108.8 мянган төгрөгийг тээвэр шатахууны зардалд, шуудан холбооны зардлаас 58.0 мянган төгрөгийг тээвэр шатахууны зардалд зэрэг нийт **442.2** мянган төгрөгийг,
- ✓ Түнхэл тосгоны соёлын төв нь нормын хувцас, зөөлөн эдлэл худалдан зардлаас 36.8 мянган төгрөгийг БҮТЭЗ худалдан авах зардалд, бараа үйлчилгээний зардлаас 87.3 мянган төгрөгийг БҮТЭЗ худалдан авах зардалд зэрэг нийт **124.1** мянган төгрөгийг,
- ✓ Хэрх тосгоны соёлын төв нь нормын хувцас зөөлөн эдлэл худалдан авах зардлаас 36.8 мянган төгрөгийг БҮТЭЗ, хөдөлмөр хамгааллын хэрэглэл худалдан авах зардлаас 79.2 мянган төгрөгийг ном худалдан авахад зэрэг нийт **116.0** мянган төгрөгийг,
- ✓ Тарнийн сургууль нь хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас **250.0** мянган төгрөгийг албан томилолтын зардалд,
- ✓ Тарнийн цэцэрлэг нь хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас **296.0** мянган төгрөгийг албан томилолтын зардалд тус тус бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан.

Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална", 5.1.2 дахь "Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх"

батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул зардлыг бодит тооцоо судалгаан дээр үндэслэж, үнэн зөв төлөвлөж байх.

4.4.2 Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:

Илрүүлэлт: Холбогдох албан тушаалтны захирамж, шийдвэр гараагүй буюу зарцуулах эрх үүсээгүй байхад ЗДНХ-өөс **11,135.1** мянган төгрөгийг, ИТХ нь **2,016.9** мянган төгрөгийг тус тус зарцуулж, бүртгэл тайланд тусгасан байна.

Өгсөн зөвлөмж: Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно", 13.7 дэх "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн нь санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байгаа бөгөөд цаашид анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл, тайланд тусгаж байх.

4.4.3 Анхан шатны баримт материалтай холбоотой:

Илрүүлэлт: Үйлст эмнэхүй, Хараа манал, Ачит амирлуулагч ӨЭМТ нь төлбөрийн хүсэлтийг Хаан банкны тамга тэмдэг, гарын үсгээр баталгаажуулаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Энэ нь Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно", 13.7 дэх "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн нь санхүүгийн тайлангийн "Иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байгаа бөгөөд цаашид анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл, тайланд тусгаж байх.

Илрүүлэлт: Хэрх тосгоны ЭМТ нь эмийн сангийн **2,580.5** мянган төгрөгийн кассын орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд орлого орсон тухай бүр бус бөөн дүнгээр төвлөрүүлсэн байна.

Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын 1-р хавсралтаар баталсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 3.12 дахь "Эрх бүхий ажилтан хураасан орлогоо өөрийн байгууллагын бүртгэлийн дансанд ажлын 1 хоногт багтаан тушааж сар бүрийн эцэст зарагдсан тасалбарын бүртгэл болон орлого цуглуулсан баримтын (зарагдсан тасалбараас өөрт үлдэх хувь) тооцоог гаргаж, тайланг тушаана" гэсэн заалтыг зөрчсөн нь санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байгаа бөгөөд цаашид орлогыг тухай бүр тушааж, мөнгөн кассын үйл ажиллагааны журмыг мөрдөж ажиллах.

Илрүүлэлт: ИТХ нь өмч хамгаалах зөвлөлийн хурлаар засвар үйлчилгээ зайлшгүй хийх шаардлагатай эсэх, төсөв тооцоо, судалгаа зэрэг асуудлыг хэлэлцүүлж, дүгнүүлэлгүйгээр автомашины засвар үйлчилгээнд нийт **20,541.3** мянган төгрөгийн сэлбэг хэрэгслийн зардал гаргасан байна.

Өгсөн зөвлөмж: Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх,

санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 13.7 дэх “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг тус тус зөрчиж байгаа бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул цаашид анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх.

Илрүүлэлт: Тарнийн сургууль нь 339.5 мянган төгрөгийн, цэцэрлэг нь 426.0 мянган төгрөгийн шатахууныг шаардах хуудсаар зарлагадаагүй, жолоочийн тооцооны хуудсанд ирсэн, явсан болон зарцуулсан км, спидометрийн заалтыг бүрэн бүртгээгүй, автомашины 100 км-т зарцуулах шатахууны нормыг мөрдөж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар “Маягт заавар батлах тухай” тушаалын хавсралт “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ыг тус тус зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул цаашид анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх.

Илрүүлэлт: Түнхэл болон Хэрх тосгоны ЭМТ-үүд нь холын дуудлагад очиж үйлчлэхдээ замын бартаа саадыг тооцоололгүй автомашины 100км-т зарцуулах шатахууны тогтоосон нормыг хэтрүүлэн зарцуулах эрсдэл үүссэн байна. Энэ нь Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалаар баталсан “Жишиг норм батлах тухай” журмын 2-т “Автомашины шатахуун зарцуулалтын жишиг норм, шатахуун зарцуулалтын жишиг нормыг нэмэгдүүлэх болон бууруулах нөхцөлүүд, автомашин, түүний үндсэн агрегат, зангилаанууд, резин дугуй, зай хураагуурын эдэлгээний нөөцийн доод хязгаарын жишиг норм, түүнийг нэмэгдүүлэх болон хорогдуулах нөхцөлүүдийг харгалзан өөрсдийн ажил үйлчилгээнийхээ онцлогт нийцүүлэн мөрдөж ажиллахыг ...” гэсэн заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Автомашины шатахуун зарцуулалтын сорил, туршилтыг явуулсны үндсэн дээр бодит зарцуулалтад тулгуурлан шатахууны нормыг шинэчлэн тогтоож, мөрдөж ажиллах.

4.4.4 Төлбөрийн цахим баримттай холбоотой:

Илрүүлэлт: Тайлант онд ЗДТГ нь 255,717.8 мянган төгрөг, ИТХ нь 69,968.4 мянган төгрөг, Түнхэл тосгоны Захирагчийн алба нь 3,320.0 мянган төгрөг, Хэрх тосгоны Захирагчийн алба нь 388.6 мянган төгрөг, Ойн анги нь 2,520.3 мянган төгрөг, Номын сан нь 272.7 мянган төгрөг, Хүүхдийн ордон нь 22,389.2 мянган төгрөг, Түнхэл тосгоны соёлын төв нь 2,927.9 мянган төгрөг, Үйлст эмнэхүй ӨЭМТ нь 10,963.6 мянган төгрөг, Хараа манал ӨЭМТ нь 6,719.3 мянган төгрөг, Ачит амирлуулагч ӨЭМТ нь 4,096.6 мянган төгрөг, Хэрх тосгоны соёлын төв нь 4,998.7

мянган төгрөг, Тарнийн сургууль, цэцэрлэг нь 22,962.8 мянган төгрөгийн зэрэг нийт **407,245.9** мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалтыг болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасныг зөрчсөн ба санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул цаашид төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 06 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Зөрчлийн товч утга	Үүнээс											
				Нийт алдаа, зөрчлийн дүн		Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар															
1			ИТХ нь албан томилолтын зардлыг давхардуулан олгосон.	1	200.0			1	200.0						
2			ЗДТГ нь өндөр настны тэтгэвэр тогтоолгосон албан хаагчид олгох тэтгэмжийг илүү тооцож олгосон.	1	1,913.0			1	1,913.0						
3			Түнхэл тосгоны Захирагчийн алба нь нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлаас албан хаагчдад биеийн тамирын хувцас худалдан авсан.	1	1,108.6			1	1,108.6						
4			Түнхэл тосгоны ЭМТ нь ур чадварын нэмэгдэл болон хавсран ажилласан цалинг зөрүүтэй тооцож олгосон.	1	335.7			1	335.7						
5	ТТЗ	СЭА-2022/07-НА-СТА-ТТЗ	Түнхэл тосгоны ЭМТ нь эмийн сангийн төлбөр тооцоог хянаж баталгаажуулаагүйгээс эмийн орлогыг дутуу төвлөрүүлсэн.	1	1,341.5			1	1,341.5						
6			Хэрх тосгоны ЭМТ нь орон тоонд тусгагдаагүй дотоод аудиторын албан тушаалыг хавсран гүйцэтгүүлж, нэмэгдэл олгосон.	1	567.4			1	567.4						
7			ТТЗ нь зайлшгүй шаардлага үүсээгүй байхад тодотгол хийсэн.	1	155,646.4			1	155,646.4						
8			ИТХ-ын мэдээлэл сурталчилгааны батлагдсан төсвөөс хуралдааны зардалд, багийн ИНХ-ын цалингийн зардлаас ИТХ-ын цалингийн зардалд гэх мэт хөтөлбөр хооронд гүйлгэн.	1	2,830.3			1	2,830.3						

